



**ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО**

# АГУУЛГА

- НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
- ХОЁР. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАСАГЛАЛ, БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ
- ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ
- ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ХЭМЖЭЭ
- ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ
- ЗУРГАА. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
- ДОЛОО. ЭРСДЭЛИЙН ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ
- НАЙМ. ДОТООД АУДИТ БА БАТАЛГААЖУУЛАЛТ

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү бодлогоор “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “ЛэндМН” эсхүл “Компани” гэх)-ийн эрсдэлийн удирлдагын тогтолцоог бий болгох, өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлх урьдчилан сэргийлэх бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг хангах, үр ашигтай хяналтын тогтолцоог бий болгох, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарчмыг тодорхойлоход оршино.

1.2. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн цар хүрээ буюу төрөл, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэлийг хянах, үнэлэх, хариу арга хэмжээ авах, тайлагнах, удирдах бүтэц, чиг үүрэг, үйл явц болон тэдгээрийг зохицуулах бодлого, журам, заавар, аргачлалаас бүрдэнэ.

1.3. ЛэндМН нь энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн үйл ажиллагаа болон Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын журам, болон Монгол улсын холбогдох бусад хууль, эрх зүйн акт, эрсдэлийн зохистой удирдлагын олон улсын зарчимд нийцүүлэн ажиллана.

1.4. Энэхүү бодлогод өөрчлөлт оруулах асуудлыг ЛэндМН-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо (цаашид “ЭУХ” гэх)-ны шийдвэрийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл батална.

## ХОЁР. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАСАГЛАЛ, БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ


2.1 ЛэндМН-ийн эрсдэлийн удирдлага нь засаглалын дараах бүрэлдэхүүнтэй байна.

2.1.1 Хамгаалалтын 3 бүс;

2.1.2 Засаглалын хороод;

2.1.3 Засаглалын бичиг баримт-Бодлого, журам, заавар.

2.2 ЛэндМН нь эрсдэлийн удирдлагыг дараах бүтцээр хэрэгжүүлнэ:



**2.3** ЛэндМН нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ дараах гурван (3) давхар хамгаалалтын бүсийн хяналтыг хэрэгжүүлнэ.

Хамгаалалтын бүс	Хамаарах нэгж	Чиг үүрэг
I бүс Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ	Бизнесийн болон тэдгээрт дэмжлэг үзүүлэх нэгж	- Эрсдэлийг хариуцаж, удирдах эзэн буюу нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гарах эрсдэлийг тодорхойлох, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, хяналтад байлгах, удирдах.
II бүс Эрсдэлийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлнэ	Эрсдэлийн хариуцсан нэгж	- Эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлох, эрсдэлийн удирдлагын бодлого, журам, зааврыг боловсруулах, хянах, шинэчлэх, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, хязгаарыг тодорхойлох, батлуулах, хянах, мониторинг хийх; - Хамгаалалтын I бүсийн эрсдэлийн удирдлага, хяналтын зохион байгуулалт, үйл ажиллагаанд мониторинг хийх, заавар, зөвлөмжөөр хангах.
III бүс Хараат бус баталгаажуулалтаар хангана.	Дотоод аудитын нэгж	- Хамгаалалтын I бүсийн хэрэгжүүлж буй хяналтын тогтолцоо, түүний гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналтын тогтолцоонд сайжруулах шаардлагатай сул талуудыг тодорхойлох; - Хамгаалалтын II бүсийн тавьж буй хянан нийцүүлэлт, үнэлгээ, тайлагналын үр дүнтэй байдалд хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх; - Эрсдэлд суурилсан үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлага, түүний засаглал, дотоод хяналтыг баталгаажуулж үнэлэх, ТУЗ-д тайлагнах.

**2.4** Бизнесийн болон тэдгээрт дэмжлэг үзүүлэх нэгжүүд нь Компанийн бизнесийн стратеги, бизнес төлөвлөгөө, төсөвт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхдээ, өөрийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг хариуцан, бизнесийн үйл ажиллагааг эрсдэлийн удирдлагын бодлогод нийцүүлэн ажиллах ба Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээтэй нийцэж байгаа эсэхийг тогтмол хянан, баталгаажуулж ажиллана.

**2.5** Эрсдэлийн хариуцсан нэгж нь эрсдэлийн удирдлагын бодлогыг Компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөө, Монгол улсын хууль, тогтоомж, эрх зүйн акт болон олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн сайжруулах, бодлого, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор бизнесийн нэгжүүдэд сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, түүний үр ашигтай байдал болон Компанийн үйл ажиллагааны эрсдэлийн төлөв эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, хязгаарын хүрээнд байгаа эсэхэд хараат бусаар хяналт тавьж ажиллана.

**2.6** Гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нь Компанид эрсдэлийн соёлыг төлөвшүүлж, ажилтан бүрийг ажил, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь чиглүүлэх ба энэхүү болон бусад эрсдэлийн бодлогоор баталсан эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээний хүрээнд ЛэндМН-ийн бизнесийн үйл ажиллагааг удирдан явуулна.

**2.7** Дотоод аудитын нэгж-ажилтан нь эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хараат бус, бие даасан хяналтыг хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, хяналтын системийн зөв зохистой байдалд үнэлэлт, дүгнэлт өгч ажиллана.

## **ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ**

3.1 ЛэндМН-ийн үйл ажиллагаа, бизнесийн зорилтод сөрөг нөлөө үзүүлсэн эсхүл нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийг, тэдгээрийн хүчин зүйл, үр дагавраас хамааруулан дараах төрөлд хуваана.

- 3.1.1 Зээлийн эрсдэл;
- 3.1.2 Зах зээлийн эрсдэл;
- 3.1.3 Хөрвөх чадварын эрсдэл;
- 3.1.4 Өөрийн хөрөнгийн эрсдэл;
- 3.1.5 Үйл ажиллагааны эрсдэл;
- 3.1.6 Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл;
- 3.1.7 Комплаенсийн эрсдэл;
- 3.1.8 Нэр хүндийн эрсдэл;
- 3.1.9 Стратегийн эрсдэл;

3.2 Эрсдэлийн төрөл тус бүрийн хамгаалалтын I болон II дугаар бүст хамаарах нэгж, албан тушаалтныг ЛэндМН-ийн Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж, түүний удирдлага нь бусад эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулан, жилд нэгээс доошгүй удаа хянаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг оруулах санал хүргүүлж болно.

## **ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ХЭМЖЭЭ**

4.1 ЛэндМН нь Эрсдэл даах чадварын хүрээнд Компанийн стратеги зорилт болон бизнес төлөвлөгөөндөө хүрэхэд хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн хэмжээг тодорхойлох ба үүнийг Үйл ажиллагааны гүйцэтгэлийн зорилтоос тусдаа ялгаатай авч үзнэ.

4.2 Хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн хэмжээ дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

4.2.1 Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг тогтоох зарчим буюу Компанийн эрсдэлийн төлөвийг хянаж, удирдах суурь зарчим буюу чиглэл;

4.2.2 Бизнесийн хэвийн үйл ажиллагааны хэмжигдэхүүн (Business as usual) буюу Компанийн үйл ажиллагаа хэвийн түвшинд байгааг илэрхийлэх, энэхүү болон эрсдэлийн удирдлагын бусад баримт бичгээр тодорхойлсон эрсдэлийн хязгаар болон эрсдэлийг хүлээн зөвшөөрөх чанарын шалгуур үзүүлэлт;

4.2.3 Хямралын нөхцөлийн стресс тестийн үр дүн буюу хямралын үед Компанийн зүгээс удирдах боломжтой эрсдэлийн хэмжээ.

4.3 Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг тогтооход дараах зарчмыг баримтална:

4.3.1 Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ нь ЛэндМН-ийн бизнес загвар болон стратегийн зорилтод нийцсэн бөгөөд зохицуулагч байгууллагаас тавигдах шаардлагын хүрээнд байна;

4.3.2 Бизнесийн үйл ажиллагааг батлагдсан эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээний хүрээнд явуулна;

4.3.3 Эрсдэлийг хүлээн зөвшөөрөхдөө өгөөжийг харгалзан үзнэ;

4.3.4 Хамгаалалтын I бүс нь өөрийн чиг үүрэгтэй холбоотой хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжүүрийг эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээний хүрээнд тодорхойлж, мөрдөх ба хамгаалалтын II бүс түүнд хяналт тавина.

## **ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ**

**5.1** Эрсдэлийн удирдлагын зарчим: ЛэндМН нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

**5.1.1** Үнэ цэнийг бий болгох: Эрсдэлийн удирдлага нь ЛэндМН-ийн үнэт зүйлийг сахин хамгаалах, хууль ёсыг дээдлэн, сайн засаглалыг бүрдүүлэх, стратегийн зорилгыг хэрэгжүүлж, өрсөлдөх чадвартай, үр ашиг бүхий, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй байгууллагыг бий болгох хувь нэмрээ оруулдаг байх ёстой.

**5.1.2** Харилцагчийн өмнө хүлээх үүрэг: ЛэндМН нь өөрийн үйл ажиллагаанд учирч болох эрсдлийг тооцоолохоос гадна хувьцаа эзэмшигч болон нийт харилцагч, түншүүдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг эрмэлзэж ажиллана.

**5.1.3** Бүхий л үйл ажиллагааны салшгүй хэсэг байх: Эрсдэлийн удирдлага нь ЛэндМН-ийн Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын хариуцах ажил байхын зэрэгцээ өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх, хянах үүрэгтэй байна.

**5.1.4** Шийдвэр гаргах үйл явцын нэг хэсэг байх: Эрсдэлийн удирдлага нь ажилтнуудад мэдрэмжээрээ бус мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, эрсдэлийг эрэмбэлэн, нэн чухал эсвэл нэн эрсдэлтэйг эхлэн шийдэх боломжийг олгоход чиглэнэ.

**5.1.5** Шат дараалсан, уялдаа холбоотой, цаг хугацааны хэмжүүртэй байж тууштай, найдвартай бөгөөд эерэг үр дүнг бий болгоход чиглүүлж ажиллана.

**5.1.6** Бодит байдалд суурилах: Эрсдэлийн удирдлага нь түүхэн мэдээлэл, бусад нэгжийн санал, ажиглалт, урьдчилсан таамаг болон, эрсдэлийн дүгнэлт зэрэг бодит мэдээллийг үндэслэх ба хэрэгжих боломжтой байна.

**5.1.7** Уялдан зохицох: Гадаад болон дотоод орчны нөхцөл байдлаас шалтгаалж үйл явдал, эрсдэл өөрчлөгдөх магадлалтай. Иймд эрсдэлийг удирдах арга барилаа шинэчилж, сайжруулж ажиллана.

**5.1.8** Ил тод байх: ЛэндМН ирээдүйд гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоолж, мэдэгдэж буй бүх эрсдэлийн талаар ажилтан бүр мэдэж байгаа эсэхийг баталгаажуулна.

**5.1.9** Бүх талуудын оролцоог хангах: Эрсдэлийн удирдагыг хэрэгжүүлэхэд Компанийн бүхий л ажилтнуудыг зохих байдлаар оролцуулна. Эрсдэлийн удирдлагыг Компанийн гишүүн бүрт хамаатай болгох нөхцөлийг бүрдүүлэн, эрсдэлийг тодорхойлоход ажилтан бүр санал бодол, дуу хоолойгоо илэрхийлэх нөхцөлийг бий болгоно.

**5.1.10** Эрсдэл, өгөөжийг тэнцвэржүүлэх: ЛэндМН нь бүхий л үйл ажиллагаандаа эрсдэл, өгөөжийн оновчтой харьцааг хадгалан, хяналт тавьж ажиллана.

**5.1.11** Хараат бус, бие даасан байх: Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ хараат бус, хөндлөнгийн байр сууринаас үнэлж, дүгнэнэ.

5.1.12 Тайлагнах: Нэгжийн ажилтан бүр олж илрүүлсэн эрсдэлийг шууд удирдлагадаа шуурхай мэдээлдэг байна. Бүх шатны удирдлагууд өөрийн хариуцсан нэгж болон түүнд хамаарах үйл ажиллагаанд хамаарах эрсдэлийн тайланг Хамгаалалтын II бүс болон Эрсдэл хариуцсан нэгжид тогтмол, үнэн зөв тайлагнана.

5.2 Эрсдэлийн соёл: ЛэндМН-ийн нийт ажилтнууд нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам зааврыг дагаж мөрдөн, эрсдэлийн талаарх мэдлэг мэдээлэлтэй байх ба өөрийн хариуцсан ажил, чиг үүргийг хэрэгжүүлэхдээ учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, удирдах үүрэгтэй. ЛэндМН нь эрсдэлийн соёлыг бий болгоход нийт ажилтнуудад эрсдэлийг удирдах техникийн арга барилаас гадна эрсдэлд хандах хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалтыг зохион байгуулна.

## ЗУРГАА. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

6.1 ЛэндМН нь эрсдэлийн удирдлагыг дараах процессоор хэрэгжүүлнэ.



6.2 Чиг хүрээг тодорхойлох (Establish Context): Эрсдэлийн удирдлагын чиг хүрээг тодорхойлж, эрсдэлийн төрөл, үйл ажиллагаанаас хамаарч эрсдэлийг хэрхэн илрүүлэх, үнэлэх, хариу арга хэмжээ авах, хянах төлөвлөгөө, чиг, хүрээг хамгаалалтын I болон II бүс хамтран тодорхойлно.

6.3 Эрсдэлийг илрүүлэх/тодорхойлох (Risk Identification): Хамгаалалтын I бүс өөрийн хариуцсан үйл ажиллагаа, чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох ба энэхүү үе шатанд i) Эрсдэлийн бүртгэл, ii) Эрсдэлийн тайлан гэсэн хоёр төрлийн бичиг баримтыг үйлдэнэ. илрүүлсэн эрсдэл бүрийг Эрсдэлийн бүртгэлд бүртгэж, Хамгаалалтын II бүсэд тухай бүр мэдээлж, тайлагнана.

6.4 Эрсдэлийн үнэлгээ (Risk assessment-Analysis and Evaluation): Илрүүлсэн буюу тодорхойлсон эрсдэл бүрийг Компани удирдах боломжгүй тул Эрсдэлийг чанарын шинжилгээ болон тоон үзүүлэлтээр үнэлэн, Эрсдэлийн түвшинг тогтоож, Эрсдэлийг эрэмбэлэн, хариу арга хэмжээ авах зэрэглэлийг тогтооно.

**6.5** Эрсдэлийг эрэмбэлэх (Prioritising risk): Эрсдэлийн түвшинг үндэслэн, Хавсралт 4-т заасны дагуу эрсдэлийн оноог тодорхойлох ба тухайн эрсдэлд хариу арга хэмжээ авах шаардлага, эрэмбийг эрсдэлийн оноон дээр үндэслэн дараах байдлаар тодорхойлно.

**6.6** Хариу арга хэмжээ (Risk Treatment): ЛэндМН нь олж илрүүлсэн эрсдэл, түүний үнэлгээнд үндэслэн эрсдэлээс хамгаалах хариу арга хэмжээг дараах чиглэлээр төлөвлөж, хэрэгжүүлнэ.

**6.6.1** Урьдчилан сэргийлэх (preventive actions) буюу эрсдэл гарахаас хамгаалах, учрах магадлалыг бууруулах, сааруулахад чиглэсэн арга хэмжээ.

**6.6.2** Эрсдэлийг бууруулах (contingent actions) буюу эрсдэл учрахад түүний ур дагаврыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ.

**6.7** Эрсдэлийг удирдахад эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг харгалзан үзсэний үндсэн дээр дараах арга хэмжээний аль нэгийг эсхүл хэд хэдийг хамтад нь хэрэгжүүлж болно.

Хариу арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ
Эрсдэлээс хамгаалах	Эрсдэлээс зайлсхийх бус, Эрсдэлийг удирдах; Үр дүн нь ижил байх арга хэмжээ, эсхүл бусад арга замыг сонгож хэрэгжүүлэхгүй байхад анхаарах;
Эрсдэлийг бууруулах	Удирдлагын хяналт, үйл ажиллагааг сайжруулж, тохиолдох магадлалыг бууруулах;
	Сөрөг үр дагаврыг боломжит бага түвшинд хүргэж бууруулах стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх-Жишээлбэл, Нөөц төлөвлөгөө, Бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, гэрээний хариуцлагын хамгаалалт;
Эрсдэлийг шилжүүлэх	Гэрээний үндсэн дээр хариуцлагыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн нөгөө талд/гуравдагч этгээдэд, эсхүл даатгалд шилжүүлэх;
Эрсдэлийг зөвшөөрөх	Дотоод хяналт зохистой гэж үзсэн тохиолдолд эрсдэлийг хүлээн зөвшөөрөх ба хяналтыг тогтмолжуулж, нөөц төлөвлөгөөг шаардлагатай хэсэгт зориулан боловсруулах.

## ДОЛОО. ЭРСДЭЛИЙН ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ

**7.1** Хамгаалалтын II бүс буюу Эрсдэл хариуцсан нэгж нь эрсдэлийн хяналт болон тайлагналыг үр ашигтай бөгөөд үр дүнтэй зохион байгуулах үүрэгтэй.

**7.2** Эрсдэлийн шинжилгээ болон хяналт: Хамгаалалтын I болон II бүс нь өөрийн хяналтад байх эрсдэлд хяналт тавих, шинжилгээ хийх үүрэгтэй. Эрсдэлийн төрөл тус бүрээр эрсдэлийн шинжилгээ, хяналтыг хийх аргачлал, давтамжийг тусад нь холбогдох бодлого, журам, заавраар зохицуулна.

**7.3** Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ (Contingent risk analysis): буюу учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох зорилгоор, тогтмол хугацаанд, эсхүл шаарлагатай нөхцөл байдал үүссэн үед Эрсдэл хариуцсан нэгж, түүний удирдлага зохион байгуулж, эрсдэлийн үнэлгээг хийнэ.



7.4 Урьдчилан төлөвлөөгүй эрсдэлийн үнэлгээ (Ad-hoc assessment): Бизнесийн шийдвэрийг хууль эрх зүйн хүрээнд оновчтой гаргах, үр дагавар, нөлөөлөл нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг давахаас хамгаалах зорилгоор эрсдэлийн үнэлгээг хийж болно.

7.5 Шийдвэр гаргахад эрсдэлийн бүрэн хэмжээний үнэлгээ шаардлагатай эсэхийг Эрсдэлийн хариуцсан нэгжийн удирдлага, Гүйцэтгэх захирал шийдвэрлэх ба эрсдэлийн хяналт/үнэлгээний үр дүнг холбогдох эрх бүхий этгээд, эсхүл хороо шийдвэр гаргахдаа харгалзан үзнэ.

7.6 Эрсдэлийн тайлан (Risk report): Эрсдэл хариуцсан нэгжийн удирдлага Компанийн эрсдэлийн тайлан цаг хугацаандаа, үнэн зөв, бүрэн гүйцэд бэлтгэгдэн, Эрсдэлийн хороо болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнах асуудлыг хариуцан, хэрэгжүүлж ажиллана.

## **НАЙМ. ДОТООД АУДИТ БА БАТАЛГААЖУУЛАЛТ**

8.1 Дотоод аудит нь Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, түүний хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг хараат бус байдлаар баталгаажуулан, түүнийг сайжруулахад хувь нэмэр оруулах чухал хэсэг бөгөөд дотоод хяналтын үр дүнтэй ба үр ашигтай байдалд үнэлгээ хийх, тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх замаар үр дүнтэй дотоод хяналтыг системийг бий болгоход Компанид туслалцаа үзүүлнэ.

8.2 Дотоод аудит нь ТУЗ-ийн Аудитын хорооноос баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Компанийн эрсдэлийн удирдлагын үр дүнтэй байдлыг дараах хүрээнд үнэлж, Хамгаалалтын I, II бүсэд сайжруулах зөвлөгөө өгч ажиллана.